ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 17 өдөр Дугаар А/248 Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."б" заалт, Засгийн газрын 2018 оны "Атарын 60 жил бүтээлч ажил өрнүүлэх тухай" 76 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны "Ой тэмдэглэх тухай" 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад Атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 60 жилийн ой, Хархорин сумын харъяат Хөдөлмөрийн баатар Олныхон овогт Лувсанжамбын Гомбосүрэнгийн 100 насны ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ойн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсэг (И.Доржсүрэн), сумын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

0111005?7

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2019 оны 04
дүгээр сарын 19-ний өдрийн А/118 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч – И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: - Г.Баясгалан - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
- С.Цэдэнбалжир - (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
- Д.Түмэнжаргал - (Аймгийн Хөгжимт драмын театрын дарга)
- Ц.Нэргүй - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
- Д.Лхагважав - (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн дарга, ургамал хамгаалал, хяналтын улсын ахлах байцаагч)
- Н.Дулам - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
- Н.Гуамарал - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
- Д.Лхагвабуд- (Аймгийн тариаланчдын холбооны тэргүүн) (зөвшилцсөнөөр)
- Г.Янжив -(Л.Гомбосүрэн сангийн тэргүүн) (зөвшилцсөнөөр)
- Сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга – Б.Батцэнгэл (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

-oOo-

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/216 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

# АТАР ГАЗАР ЭЗЭМШИЖ, ГАЗАР ТАРИАЛАНГ БИЕ ДААН САЛБАР БОЛГОН ХӨГЖҮҮЛСНИЙ 60 ЖИЛИЙН ОЙ УГТСАН БҮТЭЭЛЧ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Тоо хэмжээ | Хүрэх үр дүн | Хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Санхүүжилт сая/төг |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр | | | | | | | |
| 1.1 | Ой угтсан бүтээлч ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулах | 1 | Төлөвлөгөө батлагдаж хэрэгжсэн байна. | 4 дүгээр сар | Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар /цаашид ХХААГ гэх/ | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /цаашид ХОХБТХ гэх/ | |
| 1.2 | Аймгийн тариаланчдын зөвлөгөөн зохион байгуулах | 1 | Газар тариалангийн салбарт тулгамдаад байгаа асуудлуудын талаар хэлэлцэх, сүүлийн үеийн техник технологийн мэдээлэл хийж, арга зүйн заавар зөвлөгөө өгсөн байна. | 4 дүгээр сар | ХХААГ, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар /цаашид Арвайхээр сумын ЗДТГ гэх/ | ХОХБТХ, Сумын Засаг дарга нар | Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөрийн санхүүжилт |
| 1.3 | Хархорин сум, Сангийн аж ахуйн дарга Хөдөлмөрийн баатар, Л.Гомбосүрэн агсны 100 жилийн ойн арга хэмжээг тусгай хөтөлбөрөөр тэмдэглэн өнгөрүүлэх | Төлөвлөгөөний дагуу | Ой тэмдэглэх төлөвлөгөө батлан, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | 1-3 дугаар улирал | Хархорин сумын Засаг даргын Тамгын газар /цаашид Хархорин сумын ЗДТГ гэх/, Л.Гомбосүрэн сан | ХОХБТХ, ХХААГ | |
| | | 1 | Хархорин сум, Сангийн аж ахуйн дарга Хөдөлмөрийн баатар Л.Гомбосүрэн агсны нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнгийн хашааг шинэчлэх санхүүжилтийг шийдвэрлэх | 2-3 дугаар улирал | Аймгийн ЗДТГ | Гомбосүрэн сан | |
| | | 1 | Хархорин сум, Сангийн аж | 2 -3 | Хархорин сумын | Гомбосүрэн сан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ахуйн дарга Хөдөлмөрийн баатар Л.Гомбосүрэн агсны 100 жилийн ойн баярын хурал, урлагийн арга хэмжээ, наадмын нээлтийг зохион байгуулах | дугаар улирал | ЗДТГ, Аймгийн Хөгжимт драмын театр | | |
| 1.4 | Аймгийн газар тариалангийн салбарын түүхэн дурсамж ном хэвлүүлэх | 1000 ш | Салбарын үе үеийн тариаланчдын мэдээллийг хойч үедээ өвлүүлэх дурсамжит ном хэвлүүлсэн байна. | 1-3 дугаар улирал | ХХААГ | Мэргэжлийн холбоод, Ажлын хэсэг | Орон нутгийн төсөв |
| 1.5 | Газар тариалангийн салбарт нэвтэрч буй дэвшилтэт техник, технологийн үзүүлэх сургуулийг Хархорин суманд зохион байгуулах /үр тариа, жимс жимсгэнэ/ | 1 удаа | Орон нутгийн тариаланчдад шинжлэх ухааны ололтыг таниулах, мэдээлэх ажлыг тариалангийн талбайд биетээр үзүүлж таниулсан байна. | 7 сард | ХХААГ | Хархорин сумын ЗДТГ, Хөдөө аж ахуйн тасаг | Төсөл хөтөлбөрийн санхүүжилт |
| 1.6 | Өндөр өртөг бүхий хүлэмжийн таримлыг ил талбайд тариалж турших, хүнсний болон эмчилгээний ач холбогдол бүхий ховор ургамал, эрт ургацын хүнсний ногооны тариалалтын технологийн үзүүлэх сургуулийг Баруунбаян-Улаан суманд зохион байгуулах | 1 удаа | | 8-р сар | ХХААГ | Баруунбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газар /цаашид Баруунбаян-Улаан сумын ЗДТГ гэх/ | Төсөл хөтөлбөрийн санхүүжилт |
| 1.7 | Атар газар эзэмшиж, газар тариаланг бие даан салбар болгон хөгжүүлсний 60 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг Хархорин суманд зохион байгуулах | 1 удаа | Хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн байна. | 11 дүгээр сар | ХХААГ, Хархорин сумын ЗДТГ | ХОХБТХ, Аймгийн Хөгжимт драмын театр, Мэргэжлийн холбоод, | Орон нутгийн төсөв |
| 1.8 | Газар тариалангийн салбарт үр бүтээлтэй ажилласан болон ажиллаж байгаа тариаланчид, мэргэжилтнүүдийн тодорхойлолтыг холбогдох байгууллагад хүргүүлэх | 1 удаа | Ахмад болон, ажил үйлсээрээ шалгарсан тариаланчид мэргэжилтнүүдийн тодорхойлолт холбогдох байгууллагуудад хүргэгдсэн байна. | 1-2 улирал | ХХААГ, Сумдын ЗДТГазар | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид ХХААХҮЯ гэх/, ХОХБТХ, Мэргэжлийн холбоод | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9 | Атрын 60 жилийн ойн медаль захиалах | 1000 | Тариаланчид ойн медалиар шагнагдсан байна. | жилдээ | ХХААГ, Сумдын ЗДТГазар | ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоод | Иргэн, аж ахуйн нэгжүүд |
| 1.10 | Ажил мэргэжлийн “Атарчин” уралдаан зарлаж зохион байгуулах | 3 | Ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулагдсан байна | Жилдээ | ХХААГ, Сумдын ЗДТГазар | Мэргэжлийн холбоод | Иргэн, аж ахуйн нэгжүүд |
| 1.11 | “Тариаланчид дуулж байна” улсын уралдаанд аймгийн тариаланчдын төлөөллийг оролцуулах | 1 | Тариаланчид уралдаанд оролцсон байна | 2-3 дугаар улирал | ХХААГ, Сумдын ЗДТГазар | ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоод | Аж ахуй нэгж, иргэдийн хөрөнгө |
| 1.12 | Аймгийн тариаланчдын урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах | 19 сум | Хүндэтгэлийн концертонд оролцох авъяаслаг тариаланчдыг шалгаруулсан байна | 3-р улирал | ХХААГ, Сумдын ЗДТГазар | Мэргэжлийн холбоод, Хархорин суманд | Тариаланчдын хандиваар |
| Хоёр. Газар тариалангийн үйлдвэрлэл, бүтээн байгуулалтын хүрээнд | | | | | | | |
| 2.1 | Хүнс, хөдөө аж ахуйн газраас бүх сумдад “Атрын аян”-ы төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмжөөр ханган, таримлын технологийн сургалт зохион байгуулж ажиллах | 19 сум | Арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | 3 сар | ХХААГ | Сумдын ЗДТГ | ХХААГ |
| 2.2 | Аймгийн нийт тариалангийн талбайн нэгдсэн мэдээллийн сан бий болгох | 1 | Тариалангийн 25009.9 га талбайг нарийвчлан бүртгэлжүүлсэн байна. | 1-4 улирал | ХХААГ | Сумдын ЗДТГазар | |
| 2.3 | Орчин үеийн технологид нийцсэн, бүтээмж өндөртэй техникийн шинэчлэл хийх, өрхийн болон фермерийн хэрэгцээнд нийцсэн бага, дунд хүчин чадалтай техник, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад лизинг, хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих | Захиалга, хэрэгцээгээр | Захиалга хэрэгцээнд тулгуурлан техник, тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. | 1-4 улирал | ХХААГ, Сумын Засаг дарга нар | Тариалан эрхлэлтийг дэмжих сан /цаашид ТЭДС гэх/, Сумдын ЗДТГазар, Аж ахуй нэгж, иргэд | Улсын төсөв, Төсөл хөтөлбөр, аж ахуй нэгж, иргэдийн хөрөнгө |
| 2.4 | Хархорин, Арвайхээр сумдын техник дундын төвийн техникийн шинэчлэлийг хийж үйл ажиллагааг аж ахуйн тооцоонд шилжүүлж ажиллах | 2 | Механикжилтийн түвшинг төмсний үйлдвэрлэлд 70 хувь, хүнсний ногооны үйлдвэрлэлд 20 хувьд хүргэсэн байна. | 1-4 улирал | ХХААГ, Сумдын ЗДТГ | ТЭДС, Мэргэжлийн холбоод, ААН, иргэд | Төсөл хөтөлбөр, ААН, иргэдийн хөрөнгө |
| 2.5 | Хархорин, Есөнзүйл сумдын үр тарианы аж ахуй | 2 | Гантай болон хуурайшилттай нөхцөлд үр тарианы ургацыг | 1-4 улирал | ХХААГ, Аж ахуйн нэгж, | ТЭДС, Аймгийн Засаг | Улсын төсөв, Төсөл |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгжүүдийн инженер, техникийн ажилтнуудыг чадавхжуулах, техник, технологийн шинэчлэл хийх | | алдагдалгүйгээр хураан авах технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна. | | иргэд | даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар /цаашид МХГ гэх/, Сумдын ЗДТГ | хөтөлбөр, иргэдийн хөрөнгө |
| 2.6 | Төмс, хүнсний ногооны үрийн чанар, хангамжийг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэх | 1 | Төмс, хүнсний ногооны нэр төрөл, үйлдвэрлэл нэмэгдсэн байна. | 1-4 улирал | ХХААГ, "Өрхийн тариалан-Бизнес хөгжил" ТББ | Сумдын ЗДТГ, Мэргэжлийн холбоод, Аж ахуйн нэгж, иргэд | Төсөл хөтөлбөр, иргэдийн хөрөнгө |
| 2.7 | Арвайхээр суманд бөөрөнхий сонгины үр үйлдвэрлэж, бусад сумдад нийлүүлэхэд шаардагдах хүлэмж байгуулахад дэмжлэг үзүүлж, нутгийн сортын үртэй болох | 1 | Арвайхээр суманд бөөрөнхий сонгины үр үржүүлэг хийж эхэлсэн байна. | 1-4 улирал | ХХААГ | "Бизнесийн Шинэ Санаа Нэвтрүүлэх төв" ТББ | Төсөл хөтөлбөрийн санхүүжилт |
| 2.8 | Япон улсын төслөөр хэрэгжүүлсэн бөөрөнхий сонгиныг үрслэгээр тарих арга технологийг бүх сумдад туршин нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлж нутагшсан сонгино бий болгох | 19 сум | Бөөрөнхий сонгины ургацын хэмжээ урд оноос нэмэгдэж нутагшсан сонгинотой болсон байна. | Жилдээ | ХХААГ, Сумдын ЗДТГ | "Бизнесийн Шинэ Санаа Нэвтрүүлэх төв" ТББ | Төсөл хөтөлбөр, иргэдийн хөрөнгө |
| 2.9 | Төвийн болон өндөрлөг бүсийн сумдын газар тариалангийн салбарт шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн тarimлыг түлхүү хөгжүүлэх | 6 сум | Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Уянга, Арвайхээр, Хорхорин, Хужирт сумдын хамгаалагдсан хөрсний тариалалт, хураасан ургац урьд оноос өссөн байна. Хүлэмжийн ашиглалт нэмэгдэж суурин хүн амын шинэ ургацын ногооны хангамж нэмэгдэнэ | 2, 3 дугаар улирал | ХХААГ, Сумдын ЗДТГ, Аж ахуйн нэгж, иргэд | Төсөл, хөтөлбөр, мэргэжлийн холбоод | Улсын төсөв, иргэд аж ахуй нэгжийн хөрөнгө |
| 2.10 | Хөнгөлөлттэй нөхцөлөөр жимс, жимсгэний суулгац олгож тариалалтыг нэмэгдүүлэх | Захиалга, хэрэгцээгээр | Жимс, жимсгэнэ тариалах талбай, иргэд, аж ахуй нэгжүүдийн тоо нэмэгдэнэ. | 2-3 улирал | ХХААГ, Сумдын ЗДТГ, Аж ахуйн нэгж, иргэд | ТЭДС, Төсөл, хөтөлбөр, мэргэжлийн холбоод | Улсын төсөв, Аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгө |
| 2.11 | ХХААХҮЯамнаас жил бүр зохион байгуулагддаг "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдаанд зохион байгуулалттай оролцох | 1 | Үзэсгэлэн худалдаанд оролцож, орон нутгийн бүтээгдэхүүнээ сурталчилсан байна. | 9 дүгээр сар | ХХААГ, Сумдын ЗДТГ | ХХААХҮЯ, Төсөл хөтөлбөр, Аж ахуйн нэгж, иргэд | Орон нутгийн төсөв |
| 2.12 | Тариалангийн үйлдвэрлэлд | Захиалг | Захиалга, хэрэгцээнд | 2-3 | ХХААГ, Сумдын | ТЭДС, | Улсын төсөв, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлагатай бордоо, ургамал хамгааллын бодисыг хөнгөлттэй нөхцөлөөр болон зээлээр олгох | а, хэрэгцээгээр | тулгуурлан салбарын сайдын тушаалаар батлагдсан хуваарийн дагуу бордоо, ургамал хамгааллын бодис нийлүүлэгдсэн байна. | улирал | ЗДТГ | Аж ахуйн нэгж, иргэд | Аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгө |
| 2.13 | Зах зээлд борлуулах ургамал түүний гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох, гарал үүслийг бүртгэн гэрчилгээжүүлж, таримлыг коджуулан талбайн түүхийн дэвтэр хөтөлж, тариаланчдыг баталгааны тэмдэгтэй болгох | 19 сум | Ургамлын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах, үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, тариаланчид гэрчилгээжих, гарал үүслийн баталгааны тэмдэгтэй болж, талбайн түүхийн дэвтэр хөтөлж хэвшсэн байна. | 2-4 улирал | МХГ | ХХААГ, Сумдын ЗДТГ, тариаланчид | Аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгө |
| 2.14 | Арвайхээр, Богд сумдад хүнсний ногооны төрөлжсөн өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх | 2 | Арвайхээр суманд 280м$^2$, Богд суманд 600м$^2$ бүхий өвлийн хүлэмж ашиглалтад оруулсан байна. | 1-4 дүгээр улирал | ХХААГ, Сумдын ЗДТГ | Аж ахуйн нэгж | Төсөл, хөтөлбөр, Аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгө |
| 2.15 | Тариалан эрхлэгч аж ахуй нэгжүүдийн тариалангийн талбайн хөрсийг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах | 19 сум | Тариалангийн талбайн 50 хүртлэх хувь нь хөрсний шинжилгээнд хамрагдсан байна. | 1-4 урирал | МХГ, Сумдын ЗДТГ | Дархан-Уул аймаг дахь УГТСЭШХ, ХААИС, Аж ахуйн нэгж, иргэд | Аж ахуй нэгж, иргэдийн хөрөнгө |
| 2.16 | Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд учруулсан хохирлыг тооцох аргачлалыг сумын түвшинд танилцуулах, сургалт зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллийн сан үүсгэх | 19 сум | Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд учруулсан хохирлыг тооцох аргачлалыг хэрэгжүүлсэн байна. | 1-4 урирал | Сумдын ЗДТГ, | Аж ахуй нэгж, иргэд | Улсын төсөв, Аж ахуй нэгж, иргэдийн хөрөнгөөр |
| 2.17 | Арвайхээр, Хархорин суманд хүнсний ногооны төрөлжсөн зоорь байгуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих | 2 | 200 тн-оос доошгүй багтаамжтай хүнсний ногоо хадгалах төрөлжсөн зоорьтой болсон байна. | Жилдээ | ХХААГ | ХОХБХ, Арвайхээр, Хархорин сумдын ЗДТГ, Аж ахуйн нэгж, иргэд | Орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр, Аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгөөр |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.18 | Бүрд сумын Боригдойн услалтын системийн одоогийн ашиглалтад үнэлгээ, дүгнэлт гаргаж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх | 1 | Услалтын системийг ашиглалтад оруулан усалгаатай тариалан нэмэгдсэн байна. | Жилдээ | ХХААГ | ХОХБТХ, Орон нутгийн өмчийн газар | |
| Гурав. Хэвлэл, мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр | | | | | | | |
| 3.1 | Аймгийн газар тариалангийн салбарын түүхийн дурсамж баримтат кино бүтээх | 1 | Атар газар эзэмшиж эхэлсний түүхэн замнал, салбарын ололт амжилтыг олон нийтэд сурталчлан таниулж, алдаршуулсан байна. | 1-3 дугаар улирал | ХХААГ, | ХХААХҮЯ, ХОХБТХ, Хархорин сумын ЗДТГ Мэргэжлийн холбоод, Сумдын ЗДТГ | орон нутгийн төсөв |
| 3.2 | “Тариаланчид зөвлөж байна” мэдлэг олгох телевизийн цуврал нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх | 12 | Технологийн зөвлөгөө мэдээлэл иргэдэд хүргэсэн байна. | 2, 3 дугаар улирал | ХХААГ, Сумдын ЗДТГ | Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд | Аймгийн ЗДТГ-ын гэрээт телвизүүд |
| 3.3 | Төмс, хүнсний ногоо, хүлэмжийн таримлыг тариалах чиглэлээр технологийн зөвлөмж, гарын авлага бэлтгэж олон нийтэд түгээх | 1000-аас доошгүй | Тариаланчдад гарын авлага хүргэсэн байна. | 2-3 улирал | ХХААГ | “Бизнесийн Шинэ Санаа Нэвтрүүлэх төв” ТББ, Сумдын ЗДТГ | Аймгийн ЗДТГ-ын гэрээт телвизүүд |
| 3.4 | Тариаланчдыг алдаршуулах хөрөг нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх | 5 удаа | 5 хүртлэх тариаланч хамрагдсан байна. | 2-4 улирал | ХХААГ | Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд | Аймгийн ЗДТГ-ын гэрээт телвизүүд |
| 3.5 | Атрын 60 жилийн ойн хүрээнд хийгдэж байгаа ажлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, сурталчлах | Тухай бүр | Иргэд мэдээ, мэдээллээр хангагдсан байна. | Жилдээ | ХХААГ | ХОХБХ, Хэвлэл, мэдээллийн байгууллагууд, Сумдын ЗДТГ | Аймгийн ЗДТГ-ын гэрээт телвизүүд |

-оОо-